



2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ

(2026.06.30-ны өдрийн байдлаар)

“Эрдэнэс алт ресурс” ХХК нь 2026 оны бизнес төлөвлөгөөтэй уялдуулан **41 зорилгын** хүрээнд **81 зорилтыг** дэвшүүлж, **241 арга хэмжээг** хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

БИЗНЕС
ТӨЛӨВЛӨГӨӨ

- ❑ ХҮДРИЙН НӨӨЦ НЭМЭГДҮҮЛНЭ
- ❑ ШИНЭ ТӨСЛИЙН ДЭД БҮТЦИЙН АЖЛУУДЫГ ЭХЛҮҮЛНЭ
- ❑ ШИНЭ ТӨСЛҮҮДИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙГ ЭЦЭСЛЭЖ, ЭБМЗ-ИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭН БАТЛУУЛНА
- ❑ ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД 50 МЯНГАН МОД ТАРИНА
- ❑ АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭНЭ

КОМПАНИЙН
ЗОРИЛГО

Хаягдлын санд хуримтлагдсан **Үүсмэл ордыг** ашиглан **дахин боловсруулна**

Овоот хяр төслийн **Хойд бүргэд алтны үндсэн ордыг** 2027 онд ашиглалтад оруулах бэлтгэлийг хангана

Салхитын **Зүүн алт мөнгөний үндсэн ордын** хөрөнгө оруулалтын ажлыг **2026 онд хэрэгжүүлж, 2027 онд** эдийн засгийн **эргэлтэд оруулна**

ҮР АШГИЙН
ЗОРИЛГО

189.4
ТЭРБУМ.₮

НИЙТ
ОРЛОГО

19.2
ТЭРБУМ.₮

УЛСЫН
ТӨСӨВТ

38.0
ТЭРБУМ.₮

ЦЭВЭР
АШИГ

ТӨСӨЛ
ХӨТӨЛБӨР

- ✓ **Овоот хяр** ордыг ашиглалтыг эхлүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалт
- ✓ **Хүрэнцав хайгуулын төслийн** өрөмдлөгийн ажил /12,000 тууш метр/, лабораторийн ажил, ордын гарал үүслийн судалгаа
- ✓ **Өлзийт овоо хайгуулын төслийн** баганат өрөмдлөгийн ажил, лабораторийн ажил, байгаль орчны судалгаа
- ✓ **Мухар хар толгой хайгуулын төслийн** цахилгаан хайгуулын ажил, Эрдэслэг бүрэлдэхүүний судалгаа, Археологи, Палеонтологийн судалгаа


ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ЗОРИЛГО

ХҮДЭР БОЛОВСРУУЛАЛТ
774 МЯН.ТН

ХҮДРИЙН АГУУЛГА
Мөнгө **57** гр/тн
Алт **0.1** гр/тн

ҮЙЛДВЭРЛЭХ БАЯЖМАЛЫН ХЭМЖЭЭ
7,740 ТН

БАЯЖМАЛ ДАХ АГУУЛГА
Мөнгө **4,046** гр/тн
Алт **5.6** гр/тн





ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

- ✓ “АЛТ-3” АЯНЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ 85 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД **МУ-ЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖААР АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАГДСАН. ХОЙД БҮРГЭД АЛТНЫ ҮНДСЭН ОРДОД** ХАМТРАН АЖИЛЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙГ НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛАН "ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ТАЙ ХАМТРАН ТАНИЛЦУУЛСАН.
- ✓ ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД 2026 ОНЫ ХАГАС ЖИЛД **42,000 МОД ТАРЬСАН** БӨГӨӨД **НИЙТ 603,474** МОД БУТЫГ ТАРЬСАН.
- ✓ ОРОН НУТГИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД **ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ** 2025 ОНД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН ӨНДӨР ХҮЧИН ЧАДАЛ БҮХИЙ **ЗӨӨВРИЙН ЭХОНЫ АППАРАТ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН.**
- ✓ “ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК НЬ 2025 ОНЫ ТОМ СЕГМЕНТИЙН **“ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ”-ӨӨР ШАЛГАРСАН.**
- ✓ ЧИНГИС ХААН ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНД **12 ТЭРБУМ ₮ ТӨВЛӨРҮҮЛСЭН.**
- ✓ САЛХИТЫН **ҮҮСМЭЛ ОРДЫН НӨӨЦИЙГ** ЭБМЗ-ИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭН **БАТЛУУЛСАН.**
- ✓ САЛХИТЫН **ЗҮҮН, ҮҮСМЭЛ** ОРДУУДЫН ХҮДРИЙГ ХОЛЬСОН **ХАГАС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИ ТУРШИЛТ БОЛОН ТЕХНОЛОГИ ТУРШИЛТЫН** АЖЛЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН.
- ✓ **ХОЙД БҮРГЭД АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫН ГАЗРЫН ДООРХ УСНЫ ЭРЭЛ-ХАЙГУУЛЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГ** УСНЫ ГАЗАР, УСНЫ НӨӨЦИЙН ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ 02 САРЫН 13-НЫ ӨДРИЙН I ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭН **БАТЛУУЛСАН.**
- ✓ **ХҮРЭНЦАВ ОРДЫН** НӨӨЦИЙН ТАЙЛАНГ 2026 ОНЫ 02 САРЫН 16-НЫ ӨДӨР ХЭЛЭЛЦҮҮЛЖ, В+С ЗЭРЭГЛЭЛЭЭР **9.1 ТОНН АЛТНЫ НӨӨЦИЙГ УЛСЫН НӨӨЦИЙН САНД БҮРТГҮҮЛСЭН.**
- ✓ **XV-021670** ТООТ ОВООТ ХЯР ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД **СУВАГ МАЛТАЛТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭСЭН.**
- ✓ **XV-022844** ТООТ ОВООТ ХЯР ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН ЗҮҮН БҮРГЭД ЭРЛИЙН ТАЛБАЙ, **XV-021671** ТООТ **ӨЛЗИЙТ ОВОО** ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙН ДӨЧИН ХУРАЛ-I ЭРЛИЙН ТАЛБАЙД ТУС ТУС **ӨРӨМДЛӨГИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭСЭН.**
- ✓ **МУХАР ХАР ТОЛГОЙ, ХАЛЗАН** ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД **АРХЕОЛОГИ, ПАЛЕОНТОЛОГИЙН** СУДАЛГААНЫ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭСЭН.
- ✓ САЛХИТЫН ЗҮҮН, ХОЙД БҮРГЭД, ХҮРЭНЦАВ АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫН НӨӨЦИЙГ ОЛОН УЛСЫН **JORC СТАНДАРТЫН ДАГУУ АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦИЙН** ТООЦООЛОЛ ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН.



КОМПАНИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ (2026.06.30-ны өдрийн байдлаар)



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Төлөвлөгөө

ХҮДЭР БОЛОВСРУУЛАЛТ

774 мян.тн

ХҮДРИЙН АГУУЛГА

Мөнгө 57 гр/тн
Алт 0.1 гр/тн

Гүйцэтгэл

ХҮДЭР БОЛОВСРУУЛАЛТ

297 мян.тн

ХҮДРИЙН АГУУЛГА

Мөнгө 46.7 гр/тн
Алт 0.13 гр/тн

ҮЙЛДВЭРЛЭХ БАЯЖМАЛЫН
ХЭМЖЭЭ

7,740 тн

БАЯЖМАЛ ДАХ АГУУЛГА

Мөнгө 4,046 гр/тн
Алт 5.6 гр/тн

ҮЙЛДВЭРЛЭХ БАЯЖМАЛЫН
ХЭМЖЭЭ

2,938 тн

БАЯЖМАЛ ДАХ АГУУЛГА

Мөнгө 2,987 гр/тн
Алт 5.2 гр/тн



САНХҮҮГИЙН ҮР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

НИЙТ
ОРЛОГО

98.3

ТЭРБУМ ТӨГ

ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ЗАРДАЛ

93.2

ТЭРБУМ ТӨГ

ЦЭВЭР
АШИГ

3.9

ТЭРБУМ ТӨГ

ААНОАТ

1.2

ТЭРБУМ ТӨГ

УЛСЫН
ТӨСӨВТ

14.5

ТЭРБУМ ТӨГ



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА - ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ
(2026.06.30-ны өдрийн байдлаар)



476,292
хүн цаг




0
ҮОХХ



36,691
Хүн хүч



741
Сургалт






Байгаль орчны бичиг баримтын бүрдлийн хүрээнд гүйцэтгэсэн ажлууд


- ✓ Хүрэнцав, Мухар Хар толгой, Халзан, Довжоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайнуудын **2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталгаажуулсан.**
- ✓ **MV-022843 тоот** (Хойд бүргэд алтны үндсэн орд) ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай, **XV-021670, XV-021671, XV-02844 тоот** хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайнуудын 2026 оны хайгуулын ажлын **Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг батлуулсан.**

Нөхөн сэргээлтийн ажил




- Салхит уурхайд **2026 онд 11 га техникийн нөхөн сэргээлт, 5 га биологийн нөхөн сэргээлтийн** ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нээлттэй тендерийн шатанд явагдаж байна.
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд компани нь 2021-2026 оны хагас жилийн байдлаар нийт **603,474 ширхэг мод тарьсан байна.**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлсэн байдал



“Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьж ургуулсан мод





НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд

2024 ОНД:

17 ажилтанд **391 сая** төгрөгийн дэмжлэг

2025 ОНД:

- 13 ажилтанд **27.5 сая** төгрөгийн орон сууцны урьдчилгааны дэмжлэг,
- 20 ажилтанд орон сууцны зээлийн төлбөрт **13.9 сая** төгрөгийн дэмжлэг
- **2025 онд нийт 33 ажилтанд 634.6 сая** төгрөгийн дэмжлэг үзүүлсэн буюу нийт **1 тэрбум** төгрөгийг зарцуулаад байна.

Мөн сургалтын төлбөрийн дэмжлэгийг 2025 онд магистрын түвшний сургалтад хамрагдаж буй 2 ажилтанд **10.5 сая** төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

2026 ОНД:

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд тайлант оны 1 дүгээр улиралд ажилтнуудын орон сууц, зээлийн судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2026 оны 4 дүгээр улиралд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд

- Орон нутгийн нийгмийн хариуцлагын хүрээнд Дундговь аймгийн Эрүүл мэндийн газарт 2025 онд үйлдвэрлэгдсэн “Sonoscape X5” маркийн хамгийн сүүлийн үеийн, өндөр хүчин чадал бүхий зөөврийн эхоны аппарат хүлээлгэн өгсөн. Тус аппарат нь 2025 онд үйлдвэрлэгдсэн “Sonoscape X5” маркийн аппарат бөгөөд тархины өнгөт доплер, хөх, бамбай, үе мөч, бусад биеийн булчин шөрмөс, судас, зүрх, хүүхдийн түнх, зулай, уушги зэргийн оношилгоонд ашигладаг.
- “Эрдэнэс алт ресурс” ХХК “Дусал цус-Амьдрал бэлэглэнэ” уриатай цусны донорын өдөрлөг зохион байгуулсан.
- Их газрын чулууны Байгалийн цогцолборт газрын зэрлэг амьтдад зориулан өвс тараан байршуулсан.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Дундговь аймгийн Гурвансайхан сумын хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2026 онд Орон нутгийн хөгжлийн санд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.
- Салхит уурхайн ажилтнууд нь орон нутгийн замд зам тээврийн осолд орсон 4 иргэнийг аварч, анхан шатны яаралтай тусламж үзүүлэн, эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгсөн.





ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД

Салхитын мөнгө-алтны үндсэн орд болон уурхайн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор 2026 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлууд ба цаашид хэрэгжүүлж буй ажлууд. Үүнд:

Салхит – Үүсмэл болон Зүүн алтны үндсэн орд

- Салхит мөнгө-алтны “Үүсмэл орд”-ын нөөцийн тайланг ЭБМЗ-ийн Салбар зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, ЭБМЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн ХХ-02-02 дугаар дүгнэлт, Үндэсний геологийн албаны даргын 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Н/21 тоот тушаалаар баталгаажуулж, нөөцийн улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.
- Салхитын Зүүн болон Үүсмэл ордын дээжийг хольсон технологи туршилтын ажлын лабораторийн шинжилгээний үр дүнд тулгуурлан хагас үйлдвэрлэлийн түвшний технологийн туршилтын ажлыг гүйцэтгэсэн.
- Салхитын Зүүн болон Үүсмэл ордын ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил гэрээний дагуу хийгдэж байгаа ба гүйцэтгэгчээр “Экологийн бүтээмж” ХХК нь шалгарсан. Байгаль орчны суурь судалгаа, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх зэрэг ажлууд хийгдсэн.

Овоот хяр төсөл – Хойд бүргэд алтны үндсэн орд (MV-022843)


- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах “Овоот хяр” нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд “Хойд Бүргэд” алтны үндсэн ордын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамж болон уурхайчдын тосгоны хүн амын унд, ахуйн ус хангамжийн зориулалттай “Гүн гашууны хоолой”-д явуулсан газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүнгийн тайланг Усны газар, Усны нөөцийн зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн I хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.
- “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2025 оны 85 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд МУ-ын Ерөнхий Сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Хойд бүргэд алтны үндсэн ордод хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг нээлттэй сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулан “Эрдэнэс Монгол” ХХК-тай хамтран танилцуулсан.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил гэрээний дагуу хийгдэж байна.
- Ордын нөөцийг Олон Улсын JORC стандартын дагуу ашигт малтмалын нөөцийн тооцоолол тайланг боловсруулсан.

Хүрэнцав алтны үндсэн орд


- Хүрэнцав ордын нөөцийн тайланг 2026 оны 02 сарын 16-ны өдөр хэлэлцүүлж, В+С зэрэглэлээр 9.1 тонн алтны нөөцийг улсын нөөцийн санд бүртгүүлсэн.
- Ордын нөөцийг Олон Улсын JORC стандартын дагуу ашигт малтмалын нөөцийн тооцоолол тайланг боловсруулсан.




Хүдэр боловсруулалт (мян.тн)



Үйлдвэрлэсэн баяжмал (тн)



Баяжмал борлуулалт (тн)



Борлуулалтын орлого (сая.₮)

